

# Herbalife Nutrition-ы Бие Даасан Гишүүн байх талаар миний мэдэх шаардлагатай зүйлс

## Миний оролцоо ямар байх боломжтой вэ?

Та Herbalife Nutrition-ы Бие Даасан Гишүүний хувьд:

- Хувийнхаа болон гэр бүлийнхээ хэрэгцээнд зориулж Herbalife Nutrition-ы бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй үнээр худалдан авах боломжтой.
- Herbalife Nutrition-ы бизнес боломжийг ашиглаж бүтээгдэхүүн борлуулснаар жижиглэн худалдааны ашиг хүртэх боломжтой.
- Herbalife Nutrition-ы бүтээгдэхүүн хэрэглэх, борлуулах хүсэлтэй хүмүүсийг бизнест татан оруулж компанийн олгож буй бизнесийн боломжуудыг ашиглах боломжтой.


Бие Даасан Гишүүдийн дийлэнх хувь нь бизнес эрхлэх бус харин Herbalife Nutrition-ы бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй худалдан авах зорилготой нэгддэг. Иймд 2021 онд ердийн Бие Даасан Гишүүд Herbalife Nutrition-с орлого урамшуулал хүртээгүй болно.

## Бизнесийн боломжуудын талаар миний мэдэх ёстой зүйлс

- Herbalife Nutrition-ы Бие Даасан Гишүүн болохын тулд зөвхөн Бие Даасан Гишүүний Олон Улсын Багц (109,666.00 ₮) худалдан авах шаардлагатай бөгөөд өөр ямар нэг худалдан авалт хийх шаардлагагүй юм.
- Бие Даасан Гишүүд хэзээ, хэрхэн ажиллах нөхцлөө өөртөө таатайгаар шийдэх боломжтой.
- Ихэнх хүмүүс хагас цагаар ажиллаж мөн танидаг хүмүүстээ эсвэл багахан нэмэлт орлого олохын тулд уулздаг хүмүүстээ бүтээгдэхүүн борлуулах замаар Herbalife Nutrition-ы бизнесийг эрхэлж эхэлдэг.
- Та орлого олно гэсэн баталгаа байхгүй юм. Аль ч бизнесийн адил Бие Даасан Гишүүдийн зарим нь амжилтанд хүрдэг ч зарим нь амжилт олдоггүй.
- Herbalife Nutrition-ы бизнесийг амжилттай явуулахад ур чадвар, хүч хөдөлмөр, цаг хугацаа шаардагдана.

## Би яаж орлого олох вэ?

Та Herbalife Nutrition-ы бүтээгдэхүүнийг хөнгөлөлттэй үнээр худалдан авч, цааш борлуулснаар орлого олох боломжтой. Таны хамгийн эхний эдлэх хөнгөлөлт нь Үнэ бодох суурийн\* 25% бөгөөд Таны борлуулалт өсөхийн хэрээр Таны хөнгөлөлтийн хувь өсөх ба дээд хэмжээ нь Үнэ бодох суурийн\* 50% хүртэл юм. Жишээ нь, Herbalife Nutrition-ы хамгийн өндөр борлуулалттай бүтээгдэхүүн болох Формула 1 коктейлийн үнэ ба эхний эдлэх хөнгөлөлтийн хувийг баруун талын зурганд үзүүлэв:

	Санал болгож буй жижиглэнгийн үнэ	MNT 95,891.00
	Гишүүний үнэ (эхний эдлэх хөнгөлөлттэй, тээвэрлэлтийн зардал, татвар тооцоогүй дүн)	MNT 74,096.75
	Боломжит ашиг	MNT 21,794.25

- Та 10 сав бүтээгдэхүүнийг эхлээд эдлэх хамгийн бага хөнгөлөлтийн хувиар худалдан авч, Компаниас санал болгож буй жижиглэнгийн үнээр цааш борлуулвал, тээвэрлэлтийн зардал болон татварын дүнг тооцохгүйгээр 217,942.50 ₮ олох боломжтой.
- Мөн түүнчлэн, та спонсор нь болж багтаа оруулсан хүмүүсийн хийсэн борлуулалтаас орлого олох боломжтой.
- Гэвч та зөвхөн хүмүүсийг бизнест татан оруулж, хэн нэгний спонсор болсноор ямар нэг орлого олох боломжгүй юм.

## Би жижиглэн борлуулалтын ашгаас гадна спонсор нь болж бизнест оруулсан хүмүүсийнхээ борлуулалтаас хэр их орлого олох боломжтой вэ?

2021 онд бүтэн 1 (нэг) жилийн турш Бие Даасан Гишүүн хэвээр байсан хүний тоо 9,381 байв. Өөрсдийн хийсэн жижиглэн борлуулалтын орлогоос гадна тэдний 29% нь буюу 2,731 хүн нь спонсор нь болж бизнест татан оруулсан Бие Даасан Гишүүдийнхээ хийсэн борлуулалтаас бөөний ашиг эсвэл бонус урамшуулал хүртсэн байна. Тэдний олсон орлогын дүнг доороос харна уу, зардал тооцоогүй дүн болно:

1+ жил Бие Даасан Гишүүн хэвээр байсан (2,731)
50% (1,366 орчим хүн) 1,041,490 ₮-с дээш орлого олсон
ТОП 10% (274 орчим хүн) 13,885,310 ₮-с дээш орлого олсон
ТОП 1% (28 орчим хүн) 197,163,123 ₮-с дээш орлого олсон

2021 онд ТОП 1% Бие Даасан Гишүүдийн бизнес эрхэлсэн хугацаа 6-с 22 хүртэл жил байв.

## Би энэ бизнесийг хийж чадахгүй бол яах вэ?

- Та Бие Даасан Гишүүний гэрээгээ хүссэн үедээ цуцлах боломжтой. Гэрээ байгуулсан өдрөөс хойш 90 өдрийн дотор цуцалсан тохиолдолд Та Herbalife Nutrition-ы Бие Даасан Гишүүний Олон Улсын Багц худалдан авахад зарцуулсан мөнгөө бүрэн буцааж авах боломжтой.
- Та Бие Даасан Гишүүний гэрээгээ цуцлахдаа сүүлийн нэг жилийн хугацаанд худалдан авсан бөгөөд савыг нь задлаагүй бүтээгдэхүүнүүдээ буцааж, худалдан авахад зарцуулсан мөнгөө буцааж авах боломжтой. Бид хүргэлтийн төлбөрийг ч мөн адил хариуцах болно.

Илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл 77008897 дугаарт хандана уу.

## МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ ДУНДАЖ УРАМШУУЛЛЫН ТАЙЛАН

\*Үнэ бодох суурь: Энэ нь бүтээгдэхүүн болгонд оноосон хөнгөлөлт болон урамшууллын тооцооллыг бодох суурь мөнгөн дүн юм.